

БАТЛАВ:”ДЦС-4”ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ү.ТӨМӨРХУЯГ

**“ИЛЧИТ ТЭРЭГНИЙ СЭЛБЭГ” НИЙЛҮҮЛЭХ  
ҮНİЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Харьцуулалт/  
гэрээний дугаар:**      **ХХА-2019/132**

**УЛААНБААТАР ХОТ  
2019 ОН**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |   |
|---|---|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | <b>1.1.</b> Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өтгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.   |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | <b>2.1.</b> Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br><b>2.2.</b> Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.  |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | <b>3.1.</b> Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) ТОӨЗ-д заасан шаардлагууд   |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | <b>4.1.</b> Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | <b>5.1.</b> Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br><b>5.2.</b> Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.   |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | <b>6.1.</b> Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>45</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.  |
| <b>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</b>            | <b>7.1.</b> Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.<br><b>7.2.</b> Бараа нийлүүлэлтийн хуваарыт заасан бараа нь нэг багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.<br><br>Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| <b>8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл</b>      | <b>8.1.</b> Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь запруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.  |

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-НЫ ХОЛБОГДОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
<b>ТӨӨЗ 1.1</b>	<p>Бусад нэмэлт шаардлага:          Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар          Үнийн санал баталгаажуулж ирүүлэх          Техникийн тодорхойлолт          Санхүүгийн тайлан <u>сүүлийн 1 жил</u></p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>“ДЦС-4” ТӨХКХ Худалдан авах ажиллагааны хэлтэс Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар:  <b>Захиргааны байр 3-р давхар 310 тоот өрөө мэргэжилтэн Л.ПУНЦАГДЭЛЭГ Утас: 70181309</b></p> <p>Огноо: <b>2019 оны 07-р сарын 08-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 00 минут</b></p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендер нээх хаяг, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>“ДЦС-4” ТӨХКХ Худалдан авах ажиллагааны хэлтэс Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>Захиргааны байр 3-р давхар 310 тоот өрөө</b></p> <p>Огноо: <b>2019 оны 07-р сарын 08-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 30 минут</b></p>
<b>ТӨӨЗ 6.2</b>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>ХХА-2019/132 “ИЛЧИТ ТЭРЭГНИЙ СЭЛБЭГ”</b> нийлүүлэх нэг багцаас бүрдэнэ.</p>

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

№	Нэг жилд нийлүүлэх боломжит тоо хэмжээ	Техникийн тодорхойлолт	Хэмжки х нэгж	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа	ТШЭХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг			
					Хэмжээ	Нийтгүүлэх эхний хугацаа	Нийтгүүлэх эцсийн хугацаа	Нийтгүүлэгчийн санал болгосон хугацаа
1	Фирда диск	Д-50	1	Ширхэг	14 хоног			
2	Ремень В-2240Ш	ГОСТ 1284-68	21	Ширхэг	45 хоног			
3	Тумблер	ТВ1-1	20	Ширхэг				
4	Лампа прожектора /илчit тэрэгний/	/илчit тэрэгний/	24	Ширхэг				
5	Плунжерная пара	/илчit тэрэгний/	6	Ширхэг				
6	Секция радиаторная масляная	/илчit тэрэгний/	11	Ширхэг				
7	Зөөлөн холбоо	/илчit тэрэгний/	4	Ширхэг				
8	ТЭМ-2 втулканы резин	/илчit тэрэгний/	18	Ширхэг				
	Колодка гребневая	/илчit тэрэгний/	37	Ширхэг				

- Бараа хүргэх газар: “ДЦС-4” -ийн төв агуулахад нийлүүлэгч өөрийн зориулалтын машинаар хүргэнэ.

Дөрөв. Үнийн саналын маягт

[огноо]

**“ДЦС-4” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Ү.ТӨМӨРХУЯГ танаа**

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг **[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу захиалгаар нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний өрөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

**Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

<b>1. Шалгах болон турших</b>	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
<b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b>	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
<b>3. Оюуны өмчийн эрх</b>	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
<b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
<b>5. Баталгаат засварын хугацаа</b>	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат хугацаа <b>[нэг]</b> жил байна.
<b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. Зах зээлийн үнэ огцом өөрчлөгдсөн тохиолдолд өрсөлдөгч компаниудын үнийн харьцуулалтыг үндэс болгоно
<b>7. Төлбөр</b>	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>30</b> хоногийн дотор шуурхай хийнэ.
<b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
<b>9. Алданги оногдуулах</b>	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
<b>10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах</b>	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
<b>11. Маргааныг шийдвэрлэх</b>	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | <p>1.1. Захиалагч чанарын баталгааны бичиг, худалдан борлуулах зөвшөөрлийг шалгана.</p> <p>1.2. Нийлүүлэх барааны сав, баглаа боодол нь баталгаажсан эсэхийг шалгана</p>  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх баримт бичгүүд:</p> <p>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь, зарлагын баримт;</p> <p>2) барааны гарал үүслийн гэрчилгээ.</p> <p>1 жилийн хугацаанд саадгүй нийлүүлнэ.</p>   |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | <p>5.1. Нийлүүлэгч нь тээвэрлэлтийн болон ашиглалтын явцад баглаа боодол гэмтсэн, чанар өнгө үзэмж алдагдсан тохиолдолд 100 хувь сольж нийлүүлэх ба үүнээс гарах зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.</p>   |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | <p>7.1. Нийлүүлэгчид <b>Урьдчилгаа төлбөр</b> олгохгүй бөгөөд гэрээгээр нийлүүлсэн барааны төлбөрийн нэхэмжлэх зарлагын баримт, холбогдох баримтуудыг үндэслэн захиалагч бараа хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор төлбөрийг хийнэ.</p>   |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup></b>                  | <p>Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн барааны үнийн дүнд хэтэрсэн гүйцэтгээгүй үүргийн дүнгийн хоног дутамд <b>0,1%-ийн алданги ноогдуулна</b>.</p> <p>Захиалагч нийлүүлэгчийн төлбөрийг хугацаа хоцроосон тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн хэтэрсэн хоног дутамд <b>0,1%-ийн алданги ноогдуулна</b>.</p> <p>Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн дүнгийн <b>30%-аас</b> хэтрэхгүйбайна.</p> |

БАТЛАВ.

ДЦС-4 ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ

ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

У.ТӨМӨРХУЯГ

ЗАХИРАЛ .....

..... НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар №

Улаанбаатар хот

Нэг талаас “**ДЦС-4**” **ТӨХК** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **ХХК** (цаашид “нийлүүлэхгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2019 оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь .....-г (цаашид “бараа” гэх) ..... (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрч ..... жилийн хугацаатай гэрээг байгуулав.. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.  
Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь барааг захиалагчийн захиалгын дагуу нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:  
Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:“ДЦС-4” ТӨХК-ИЙН**

ЕИБТД ЗАХИРАЛ:

Б.ГАНХУЯГ

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

“.....” ХХК-ИЙН

ТЭЗ ДАРГА

Ж.ОТГОН

МЕНЕЖЕР

ЭЗСА-Н ДАРГА:

Д.ТӨМӨРТОГОО

ХААХ-ИЙН ДАРГА:

О.ГАНТӨМӨР

ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

Ч.БЯМБАСҮРЭН

ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН

С.ДОНИД

